



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 4



Улаанбаатар хот

Охин компани үүсгэн байгуулах тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн охин компанийг үүсгэн байгуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх заалт, Компанийн Дүрмийн 9.4.13 дах заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай, хүнсний бөөний болон жижиглэн худалдаа, хүнсний агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах Монгол хэлээр Премиум Коммерс ХХК, Англи хэлээр Premium Commerce LLC-ийг үүсгэн байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Премиум Коммерс ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн нийт хэмжээг 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,000 (арван мянган) ширхэг энгийн хувьцаанаас бүрдсэн 1,000,000 (нэг сая) төгрөгөөр баталсугай.
3. Премиум Коммерс ХХК-ийн албан ёсны хаяг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхар байхаар тогтсугай.
4. Премиум Коммерс ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Цолмонгийн Бархасыг томилсугай.
5. Премиум Коммерс ХХК-ийн дүрмийг Хавсралт 1-ээр, Эхлэлтийн тайлан тэнцлийг Хавсралт 2-оор, Хөрөнгийн жагсаалтыг Хавсралт 3-аар тус тус баталсугай.
6. Премиум Коммерс ХХК-ийн Дүрмийг Компанийг төлөөлөн баталгаажуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д зөвшөөрсүгэй.
7. Премиум Коммерс ХХК-ийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх, хяналтын дугаар авах, тамга тэмдэг авах, банканд харилцах данс нээлгэх зэргийг оролцуулаад дээрх шийдвэрүүдийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай ба/буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосугай.
8. Гүйцэтгэх захирал нь Премиум Коммерс ХХК-ийг төлөөлж харилцах данснаас гүйлгээ хийх эрх бүхий албан тушаалтнуудыг томилох, гүйлгээ хийх бүрэн эрхтэй болохыг үүгээр баталгаажуулсугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А.ГАНБОЛД			
	Г.БАТ-ЭРДЭНЭ			
	З.УЯНГА			
	Г.ЧИНЗОРИГ			
	Б.БАТ-ЭРДЭНЭ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:	Ө.ЭРДЭНЭЧИМЭГ			
	В.ГАНЗОРИГ			
	ГАРИ СТИВЕН БИОНДО			
Тогтоолын батлагдсан хувь:				